

# Аймгийн хүн ам, өрхийн танилцуулга



## Танилцуулгын агуулга

- Оршил

Танилцуулгын зорилго

Танилцуулгын аргачлал

### I. Хүн амын тооны өсөлт

1. Нас, хүйсийн бүтэц
2. Хүн амын тоо, байршил
3. Хүн амын өсөлт
4. Хүн амын наслалт
5. Хүйсийн харьцаа
6. Хүн ам зүйн ачаалал

### II. Өрхийн тоо, байршил

### III. Хүн амын ердийн хөдөлгөөн

1. Төрөлт
2. Нас баралт
3. Гэрлэлт
4. Цуцлалт
5. Үрчлэлт

- Дүгнэлт
- Хамруулсан хугацаа
- Мэдээллийн эх үүсвэр
- Нэр томъёоны тайлбар

## ОРШИЛ

Хүн амын өсөлт, нас хүйсийн бүтэц, түүний өөрчлөлт нь нийгэм, эдийн засагт шууд болон шууд бусаар нөлөөлж байдаг бөгөөд хүн амд чиглэсэн ямар бодлого, хөтөлбөр боловсруулах вэ гэдгийг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Иймд хүн ам, өрхийн үндсэн үзүүлэлтэд статистикийн арга аргачлалыг ашиглан судалгаа дүгнэлт хийж, төлөв байдлыг тодорхойлох нь зүй ёсны шаардлагатай болно.

- **Танилцуулгын зорилго**

Энэхүү танилцуулгад Говьсүмбэр аймгийн 2017, 2018 оны хүн амын тоо, түүний өсөлт, нас, хүйсийн бүтэц, дундаж нас, наслалт, ердийн болон механик хөдөлгөөний өсөлт бууралт, өрхийн байдал, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тодорхойлохыг зорилоо.

- **Танилцуулгын аргачлал**

Хүн амын статистикийн албан ёсны мэдээ тайланд тулгуурлан, холбогдох үзүүлэлтүүдийг тооцож, 2017 онтой харьцуулан дүгнэж, статистикийн хүснэгт, графикаар өсөлт бууралтыг харуулж танилцуулгыг хийлээ. Хүн ам зүйн ойлголт тодорхойлолтыг тусгайлан хийж, нэр томъёоны тайлбар нэрээр оруулав.


## I. Хүн амын тооны өсөлт

### 1. Хүн амын нас, хүйсийн бүтэц

Хүн ам зүйн судалгаа шинжилгээнд хамгийн түгээмэл хэрэглэгддэг суурь мэдээлэл нь хүн амын тоо юм. “Хүн амын тоо” гэдгийг энгийнээр тодорхойлолбол, тодорхой хугацаанд тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа нийт хүмүүсийн тоо юм.

Хүн ам зүйн судалгаа нь хүн амын тоо хэмжээ, насны бүтцийг нарийн тооцоход оршино.

Зураг 1: Хүн амын тоо, насны бүтэц, хүйсээр



### 2. Хүн амын тоо, байршил

Хүн ам, өрхийн мэдээллийн нэгдсэн цахим санд Говьсүмбэр аймгийн харьяат 17.5 мянган хүн бүртгэлтэй байгаагаас 1.7 хувь нь гадаадад оршин сууж байна. Нийт хүн амын 98.3 хувь нь суурин хүн ам байна. Суурин хүн амын тоо өмнөх оноос 3.2 хувиар нэмэгджээ.

Суурин хүн амын 73 хувь буюу 17.2 мянга нь аймгийн төвийн сум буюу Сүмбэр суманд, 5.3 хувь буюу 1.2 мянга нь хөдөөгийн сум болох Баянтал, Шивээговь сумдад 20.1 хувь нь амьдарч байна.

Хүснэгт 1. Хүн амын тоо, байршлаар

	2017	2018
Нийт хүн ам	17387	17489
Аймгийн төв	10439	10447
Сумын төв	3077	3121
Хөдөө	3871	3921

Суурин хүн амын 60.2 хувь нь аймгийн төвд, 17.8 хувь нь сумын төвд, үлдсэн 22.4 хувь нь хөдөөд амьдарч байна.


Зураг 2. Хүн амын тоо, байршлаар, бүтцээр



Хүснэгт 2. Хүн амын тоо, багаар  
2017, 2018 он

Үзүүлэлт	2017	2018
Аймгийн дүн	17387	17489
Сүмбэр	12710	12773
1	2798	2736
2	3315	3352
3	4321	4359
4	774	821
5	744	753
6	758	752
Баянтал	1240	1201
1	790	756
2	450	445
Шивээговь	3449	3515
1	2299	2365
2	1150	1150


Зураг 3. Хүн амын тоо, сумдаар,  
2017, 2018 он



### 3. Хүн амын өсөлт

Аймгийн хүн амын тоо өмнөх оноос 0.6 хувиар нэмэгдсэн хэдий ч жилийн дундаж өсөлтийн хувь 0.1 пунктээр бага байна. Сүмбэр сумын хүн амын тоо өмнөх оноос 0.4 хувиар, Шивээговь сум 1.9 хувиар нэмэгдэж, Баянтал сум 3.2 хувиар буурсан байна.

Зураг 4. Хүн амын өсөлт бууралт, хувиар 2017-2018



Хүн амын тооны өсөлтийг цэвэр шилжилт, ердийн цэвэр өсөлтөөр тооцдог. Цэвэр шилжилт нь шилжин ирсэн, явсан хүний зөрүүгээр хүн амын механик хөдөлгөөний дүнд гардаг ба аймгийн цэвэр шилжилт сүүлийн 2 жилд жил дараалан нэмэх үзүүлэлттэй гарсан нь шилжин ирэх урсгал давамгайл байгааг илэрхийлж байна. Цэвэр шилжилт нь 2018 онд 41 байсан нь өмнөх оноос 112 хүнээр бага байна.

### Хүснэгт 3: Хүн амын цэвэр өсөлт

	механик хөдөлгөөн			ердийн хөдөлгөөн		
	шилжиж ирсэн	шилжиж явсан	цэвэр шилжилт	төрсөн хүүхэд	нас барсан хүн	ердийн цэвэр өсөлт
2017	641	488	153	400	100	300
2018	568	527	41	469	88	381

#### 4. Хүн амын наслалт

Нийт хүн амын 31.2 хувийг 0-15 насны хүүхэд, 64.5 хувийг хөдөлмөрийн насны хүн ам, 6.8 хувийг тэтгэврийн насны хүн ам эзэлж байна.


#### Хүснэгт 4. Хүн амын тоо, насны бүлгээр

он	бүгд	0-15 насны		насны бүлгээр		тэтгэврийн	
		хүүхэд	хувь	хөдөлмөрийн насны	хувь	насны	хувь
2017	17387	5711	32.8	10712.0	61.6	964.0	5.5
2018	17489	5905	32.7	10537.0	60.2	1047.0	6.0

Нийт хүн амд 0-15 насны хүүхдийн эзлэх хувь 2017 оноос 0.2 пунктээр, тэтгэврийн насны хүн амынх 0.4 пунктээр нэмэгдэж, хөдөлмөрийн насны хүн амынх 1.4 пунктээр буурсан байна.

Дундаж наслалт нь насны бүлэг дэх нас баралтын коэффициентийг үндэслэн тооцсон тухайн хүний цаашид амьдрах дундаж хугацаагаар тодорхойлогддог.

#### Зураг 5. Дундаж наслалт



Аймгийн хүн амын дундаж наслалт нь 2018 он 73.6 жил болж, өмнөх оноос 1.6 пунктээр нэмэгджээ. Энэ нь улсын дунджаас 3.4 пунктээр их байна. Хүйсийн хувьд эрэгтэйчүүдийн дундаж наслалт аймгийн дунджаас 1.0 пунктээр доогуур байхад эмэгтэйчүүдийнх 2.7 пунктээр дээгүүр байна. Өөрөөр хэлбэл эмэгтэйчүүд эрчүүдийг бодвол илүү урт насалдаг байна. Хүн амыг насны бүтцийнх нь хувьд яг таллан хувааж байгаа насыг насны голч гэнэ. Аймгийн хүн амын голч нас 36.8 байна.

#### 5. Хүйсийн харьцаа

Хүн амын дундах хүйсийн бүтцийг судалснаар тухайн улс, бүсийн хүн амын ирээдүйн өсөлтийг тодорхойлох, мөн аливаа бодлого, хөтөлбөрийн үйл ажиллагаанд жендэрийн мэдрэмжтэйгээр хандах боломжтой болдог. Хүн амын хүйсийн бүтэц хэр тэнцвэртэй байгааг хэмжих төрөл бүрийн хэмжүүрүүд байдаг ч тэдгээрээс эрэгтэй/эмэгтэй хүн амын хувь, хүн амын хүйсийн харьцаа зэрэг үзүүлэлтүүдийг түгээмэл ашигладаг. Эрэгтэй/эмэгтэй хүн амын хувь гэсэн үзүүлэлтийг тооцохдоо тухайн улс/бүс дэх нийт эрэгтэй/эмэгтэй хүн амын тоог нийт хүн амын тоонд харьцуулан, 100-аар үржүүлж тооцох ба уг үзүүлэлт 50 гарвал хүйсийн бүтэц тэнцвэртэй гэж үзнэ.


$$\text{Эрэгтэй хүн амын хувь} = \frac{\text{эрэгтэй хүн ам}}{\text{нийт хүн ам}} * 100$$

$$\text{Эмэгтэй хүн амын хувь} = \frac{\text{эмэгтэй хүн ам}}{\text{нийт хүн ам}} * 100$$

## Хүснэгт 5. Говьсүмбэр аймгийн эрэгтэй/ эмэгтэй хүн амын хувь

хүйс	2017	2018
эрэгтэй	50.2	50.1
эмэгтэй	49.9	49.9

Зураг 6. Хүн амын хүйсийн байдал



2018 оны байдлаар Говьсүмбэр аймгийн хүн амын 50.1 хувь нь эрэгтэй, 49.9 хувь нь эмэгтэй хүн ам байна. Үзүүлэлтүүд ойролцоогоор 50 хувьд байгаа учир хүйсийн харьцаа ерөнхийдөө тэнцвэртэй, гэхдээ эрэгтэй хүн ам эмэгтэйгээсээ бага зэрэг илүү байна. Хүйсийн харьцаа нь эрэгтэй хүн амын тоог эмэгтэй хүн амын тоонд харьцуулсан харьцаа бөгөөд энэ нь 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоог илэрхийлнэ. Хүйсийн харьцааг насны бүлгээр нь тооцож үзвэл илүү үр дүнтэй харагдах боломжтой юм. Тооцохдоо тухайн оны эрэгтэй хүн амын нийт тоог эмэгтэй хүний нийт тоонд харьцуулж 100-гаар үржүүлнэ. Уг үзүүлэлт нь 100-тай тэнцүү гарвал хүйсийн бүтэц тэнцвэртэй гэж үзнэ.

### 5. Хүн ам зүйн ачаалал

Энэ нь тэжээгчийн тэжээж буй хүний тоог харуулдаг ба хүүхэд насны хүн ам зүйн ачаалал, өндөр настны хүн ам зүйн ачаалал, ерөнхий хүн ам зүйн ачаалал гэж 3 хувааж үздэг. Ерөнхий хүн ам зүйн ачаалал нь хөдөлмөрийн насны нэг хүнд хөдөлмөрийн бус насны хичнээн хүн ногдож байгааг харуулна.

$$ХАЗА_{хүүхэд} = \frac{P_{-14}}{P_{15-65}} * 100$$

$$ХАЗА_{хөгшид} = \frac{P_{65+}}{P_{15-65}} * 100$$

$$ХАЗА_{нийт} = \frac{P_{-14} + P_{65+}}{P_{15-65}} * 100$$

### Хүснэгт 6. Хүн ам зүйн ачаалал

	2017	2018
Хүүхэд	53.3	56.0
Хөгшид	9.0	9.9
Нийт	62.3	66.0

Хүснэгтээс харахад 2018 оны байдлаар Говьсүмбэр аймгийн хөдөлмөрийн насны 100 хүн өөрөөсөө гадна 56 хүүхэд, 10 тэтгэврийн насны хүмүүс, нийтдээ 66 хөдөлмөрийн бус насны хүмүүсийг тэжээж байгаа дүр зураг харагдаж байна. Мөн үүнээс харахад хүн ам зүйн ачаалал нь өмнөх оноос хүүхэд 2.7, тэтгэврийн насны хүн 0.9, пунктээр өссөн байна.

## II. Өрхийн тоо, байршил

Тайлант онд 5388 өрх тоологдсон нь өмнөх оноос 24 өрхөөр буюу 0.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийт өрхөөс 3167 буюу 58.8 хувь нь аймгийн төвд, 944 буюу 17.5 хувь нь

сумын төвд, 1277 өрх буюу 23.7 хувь нь хөдөөд байршиж байгаа бөгөөд нийт өрхөөс 10 буюу түүнээс дээш ам бүлтэй өрх 17 тоологдлоо.

#### Хүснэгт 7. Өрхийн тоо байршлаар

Өрх	2017	2018
Нийт өрхийн тоо	5364	5388
Аймгийн төвд	3151	3167
Сумын төвд	949	944
Хөдөөд	1264	1277

Аймгийн төвд амьдарч байгаа өрхийн эзлэх хувийн жин өмнөх оноос 0.1 пунктээр хөдөөд амьдардаг өрх 0.2 пунктээр нэмэгдсэн байна.

#### Хүснэгт 8. Өрхийн тоо, нэг өрхөд ногдох хүн амын тоо


он	нийт өрх	нийт хүн ам	нэг өрхөд ногдох хүн ам
2017	5364	17387	3.2
2018	5388	17489	3.2

Нэг өрхөд ногдох хүний тоо 2018 онд 3.2 хүн болжээ. Энэ үзүүлэлт сүүлийн жилүүдэд ойролцоо түвшинд байна.

#### Хүснэгт 9. Өрхийн тоо сум, багаар

Сум, баг	2017	2018	өсөлт
Сүмбэр	3878	3899	100.5
1	805	792	98.4
2	1059	1059	100
3	1285	1316	102.4
4	250	260	104
5	233	232	99.6
6	246	240	97.6
Баянтал	418	410	98.1
1	256	242	94.5
2	162	168	103.7
Шивээговь	1068	1079	101.3
1	693	702	100.5
2	375	377	100.4
Нийт өрх	5364	5388	100.0

#### Зураг 7. Өрх, сумдаар, 2017, 2018 он





Нийт багаас 4 баг нь 500 ба түүнээс дээш өрхтэй, 5 баг нь 200 ба түүнээс дээш өрхтэй, 1 баг нь 200 хүртэл өрхтэй байна.

### III. Хүн амын ердийн хөдөлгөөн

#### 1. Төрөлт

Төрөлт нь хүн амын нөхөн үржихүйн бодит үзэгдэл бөгөөд эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоогоор тодорхойлогдоно. Аймгийн хэмжээнд 2018 онд 498 хүүхэд төрсөн нь өмнөх оноос 19 хувиар нэмэгджээ. 2018 онд төрсөн хүүхдийн 52.0 хувийг эрэгтэй хүүхэд эзэлж байна.

#### Хүснэгт 10. Төрсөн хүүхдийн тоо, эхийн насаар

он	төрсөн хүүхэд	15-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49
2017	400	16	100	123	87	55	17	2
2018	498	30	132	149	118	47	22	0


Төрсөн хүүхдийг эхийн насаар нь авч үзвэл 25-29 насны эмэгтэйчүүдийн төрөлт илүү байна. Төрөлтийн түвшинг тодорхойлдог хэд хэдэн үндсэн үзүүлэлт байдгийн нэг нь төрөлтийн ерөнхий коэффициент (ТЕК) юм. ТЕК нь тухайн жилд мянган хүн амд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлнэ.

#### Хүснэгт 11. Насны бүлгийн төрөлтийн түвшин

он	ТЕК	төрсөн хүүхдийн тоо	15-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	ТТК	ТНК
2017	23.0	400	24.9	156.0	152.2	116.8	84.7	29.3	3.9	87.4	2.8
2018	28.5	498	46.7	206.6	203.3	160.1	76.4	38.1	0.0	111.5	3.7


1000 хүнд ногдох төрсөн хүүхдийн тоо 2018 онд 28.5 болж, өмнөх оноос 5.5 промилээр нэмэгджээ.

#### Зураг 8. Төрөлтийн тусгай коэффициент



Аймгийн хэмжээнд төрөлтийн тусгай коэффициент нь 2017 онд 87.4 байсан бол 2018 онд 111.5 болж, өмнөх оноос 24.1 промилээр нэмэгдсэн байна. Төрөлтийн тусгай коэффициент нь насны бүлэг дэх төрөлтийн ялгавартай түвшинг харуулж чаддаггүй учир уг коэффициентийг насны бүлэг тус бүрт тооцож, насны бүлэг дэх төрөлтийн түвшинг гаргаж ялгавартай харж болно..

Зураг 9. Насны бүлэг дэх төрөлтийн тусгай коэффициент



2017 онд 45-49 насны 1000 эмэгтэйд 0.8, 2018 онд 0.6 төрсөн хүүхэд ногдож, өмнөх оноос 0.2 промилээр буурсан байхад бусад насны бүлэгт 1.6-18.7 промилээр нэмэгдсэн ба 20-29 насны эмэгтэйчүүдийн төрөлтийн түвшин хамгийн өндөр байгаа нь харагдаж байна. Төрөлтийн нийлбэр коэффициент (ТНК) нь төрөлтийн түвшинг илэрхийлэх чухал үзүүлэлт бөгөөд нас баралтын түвшинг тооцоогүй тохиолдолд нэг эмэгтэйн эсвэл 1000 эмэгтэйн нийт амьдралынхаа туршид төрүүлэх хүүхдийн дундаж тоог илэрхийлнэ.

Зураг 10. Төрөлтийн нийлбэр коэффициент



Энэ үзүүлэлт нь 2017 онд 2.8 байснаа 2018 онд 3.2 болж, өмнөх оноос 0.4 промилээр нэмэгдсэн байна. Төрөлтийн нийлбэр коэффициент нь тухайн жилд амьд төрсөн хүүхдийн тоо, хүн амын тооны өсөлттэй шууд холбогдон өсч, буурч байдаг.

## 2. Нас баралт

Нас баралт нь хүн амын дунд гарч буй нөхөн үржихүйн үзэгдэл юм. Нас баралт нь тухайн газар нутгийн хүн амын нас, хүйсийн бүтэц, ажил эрхлэлтийн байдал болон нийгмийн тодорхой анги бүлэг, байршил гэх мэт олон хүчин зүйлээс шалтгаалан харилцан адилгүй түвшинтэй байдаг. Түүнчлэн хүн амын амьжиргааны түвшин, эрүүл ахуйн нөхцөл байдал ч нас баралтын түвшинд нөлөөлдөг. Аймгийн хэмжээнд 2018 онд 90 хүн нас барсан нь өмнөх оноос 10.0 хувиар буурсан.

Хүснэгт 12. Нас барсан хүний тоо, насны бүлгээр

Он	Нас баралт	0-4	10-14	15-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70+
2017	100	5	2	1	1	4	2	3	7	11	12	5	14	8	25
2018	90	3	0	1	1	3	1	4	10	7	8	11	12	4	25


2017 онд нийт нас барсан хүний 56 хувь нь, 2018 онд 64.4 хувь нь эрэгтэйчүүд байгаа нь өмнөх оноос 8.4 пунктээр өсчээ. 2018 онд нас барсан нийт хүн амын 27.8 хувийг 70 ба түүнээс дээш насныхан, 17.8 хувийг 60-69 насныхан, 21.1 хувийг 50-59 насныхан, 18.9 хувийг 40-49 насныхан, 3.3 хувь нь 0-4 насны хүүхэд байна.

### Хүснэгт 13. Нас баралтын түвшин

ОН	НБЕК	нас баралт	0-4.	10-14.	15-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70 +
2017	5.8	100.0	2.1	1.5	0.8	0.7	2.4	1.3	2.4	6.3	11.0	13.9	7.9	36.6	35.6	67.8
2018	5.1	90.0	1.3	0.0	0.8	0.7	2.0	0.7	3.2	9.0	6.9	9.4	16.3	28.0	17.7	63.8

Нас баралтын ерөнхий коэффициент (НБЕК) нь тухайн жилд 1000 хүнд ногдох нас барагсдын тоогоор илэрхийлэгддэг. 2017 онд аймгийн 1000 хүн тутмын 5.8, 2018 онд 5.1 хүн нас барж, НБЕК 2018 онд өмнөх оноос 0.7 промилээр буурчээ. Нас баралтын ерөнхий коэффициент нь нас баралтыг насны бүлгээр тодорхойлдоггүй учир нас баралтын түвшинг насны бүлэг тус бүрд тооцдог. Энэ нь насны бүлэг тус бүрд нас баралтын түвшин харилцан адилгүй байгааг харуулдаг.

Зураг 11. Насны бүлэг дэх нас баралтын коэффициент



Насны бүлэг дэх нас баралтын түвшинг сүүлийн 2 жилийн байдлаар авч үзэхэд 35-39, 40-44, 55-59, насны бүлэгт нас баралтын түвшин өмнөх оноос 0.8-8.4 промилээр нэмэгдэж, бусад насны бүлэгт 0.1-8.2 промилээр буурсан нь харагдаж байна.

### 3. Гэрлэлт


Гэрлэлт нь хүн амын гэр бүл болох явц, түүний өсөлт, өөрчлөлтийн хэмжээг харуулах бөгөөд өрх нэгдэх, тусгаарлах, зэрэг үйл явцыг илэрхийлдэг. Аймгийн хэмжээнд бүртгүүлсэн гэр бүлийн тоо 2017 онд 72, 2018 онд 89 байгаа нь өмнөх оноос 19.1 хувиар буюу 17-оор их байна.

Хүснэгт 14. Гэр бүлээ батлуулсан хүний тоо, нас, хүйсээр

	эрэгтэй		эмэгтэй	
	2017	2018	2017	2018
бүгд	72	89	72	89
18-19	1	1	3	1
20-24	22	14	25	23
25-29	25	39	30	41
30-34	13	19	7	11
35-39	4	6	1	5
40-44	3	6	2	4
45-49	2	1	2	1
50 +	2	3	2	3

Гэр бүлээ бүртгүүлсэн хүн амыг хүйсээр авч үзвэл эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд 25-29 насандаа гэр бүл болцгоодог нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Зураг 12. Гэрлэлтээ бүртгүүлсэн хүний насны бүтэц, хүйсээр



Тухайн бүс нутгийн хүн амын гэрлэлтийн түвшин нийт хүн амын дотор эзлэх гэрлэсэн хүний хувийн жин зэрэг үзүүлэлт нь хүн амын доторх төрөлтийн түвшинд шууд нөлөөлнө. Гэрлэлтийн түвшингүүдийг авч үзье. Гэрлэлтийн ерөнхий коэффициент (ГЕК) нь гэрлэлтийн түвшинг тодорхой хугацаанд тооцож, бусад бүс нутагтай зэрэгцүүлэх ерөнхий үзүүлэлт болдог. ГЕК нь тухайн жилийн 1000 хүнд ногдох гэрлэлтийн тоог харуулна. 2018 онд аймгийн хэмжээнд ГЕК нь 5 байгаа нь 1000 хүн тутамд 5 гэрлэлт ногдож байгааг харуулж байна.

Хүснэгт 15. Гэрлэлтийн түвшин, эрэгтэй насны бүлгээр

он	ГЕК	18-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50+
2017	4.1	1.5	31.0	29.0	16.8	6.7	5.6	4.1	1.8
2018	5.1	1.6	0.0	48.6	9.1	1.6	3.8	4.0	1.7

Хүснэгт 16. Гэрлэлтийн түвшин, эмэгтэй насны бүлгээр

он	18-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50+
2017	1.6	21.8	48.3	25.5	9.2	10.3	2.0	1.5
2018	1.6	36.0	55.9	14.9	8.1	6.9	1.9	2.1

2018 оны гэрлэлтийн ерөнхий коэффициент нь 2017 оноос 1.0 промилээр өссөн үзүүлэлттэй байна. ГЕК-ийн өсөлт, бууралт нь хүн амын тооны болон гэрлэлтийн өсөлт бууралтаас хамааралтай. Гэрлэлтийг гэрлэх нас, хүйсээр нь судлахын тулд нас хүйсний бүлэг дэх гэрлэлтийн коэффициент (НХБГК)-ийг тодорхойлдог. Энэ нь тодорхой нас, хүйсийн бүлгийн 1000 хүн ам тутамд ногдох тухайн нас, хүйсний бүлэг дэх гэрлэлтийн тоог илэрхийлнэ. Энэ үзүүлэлт манайд эрэгтэйчүүдийн 25-34 насанд 48.6-9.1, эмэгтэйчүүдийн хувьд 20-29 насанд 36-55.9 байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл энэ насны 1000 эрэгтэйчүүдийн 48, 1000 эмэгтэйчүүдийн 55 нь гэрлэж байгааг харуулж илтгэж байна

#### 4. Цуцлалт

Гэр бүл цуцлалт нь хүн амын ердийн хөдөлгөөний нэг үзүүлэлт болдог. Гэр бүл цуцлалтыг хамт амьдарсан хугацаагаар нь 7 бүлэгт хувааж үзлээ.


Хүснэгт 17. Гэр бүл цуцлалт, гэр бүл байсан хугацаагаар

нас	1 хүртэл	1--3	4-6	7-9	10-14	15-19	20+	бүгд
2017	0	2	5	10	10	4	3	34
2018	0	1	2	3	6	4	1	17

2018 онд цуцалсан гэр бүлийн тоо 17 байгаагийн 5.9 хувийг 1-3 жил, 11.8 хувийг 4-6 жил, 23.5 хувийг 15-19 жил, 17.6 хувийг 7-9 жил, 5.9 хувийг 20 ба түүнээс дээш жил, 35.3 хувийг 10-14 жил хамт амьдарсан хосууд эзэлж байна. Цуцалсан гэр бүлийн тоо өмнөх оноос 50 хувиар буурчээ.

Цуцлалтын ерөнхий коэффициент (ЦЕК) нь гэр бүл цуцлалтын хамгийн энгийн болон ерөнхий үзүүлэлт юм. Энэ нь тухайн бүс нутаг дээрх 1000 хүн амд ногдох цуцлалтын тоог илэрхийлдэг.

### Зураг 13. Цуцлалтын түвшин



2018 онд ЦЕК 1 байгаа нь 2017 оноос 0.9 промилээр бага байна. Зургаас харахад цуцлалтын түвшин 2018 онд буурсан үзүүлэлттэй байгаа нь харагдаж байна. Уг үзүүлэлт нь цуцлуулсан гэр бүлийн тооны өсөлт, бууралтаас шууд хамаардаг.

### 5. Үрчлэлт

Үрчлэлт бол аль ч нийгмийн тогтолцооны үед амьдрал дээр гардаг үзэгдэл билээ. Иймээс үрчлэлтийг үрчлэгдсэн хүүхдийн насны бүлгээр нь авч судлав.

### Хүснэгт 18. Үрчлэлт, хүүхдийн нас, тоогоор

нас	3 хүртэл	3-6	7-9	10 +	бүгд
2017	3	1	0	0	4
2018	4	1	2	2	9

Аймгийн хэмжээнд үрчлэгдсэн хүүхдийн тоо 2018 онд 9 болж, өмнөх оноос 2.2 дахин буюу 5 хүүхдээр их байна. Сүүлийн 2 жилд нийтдээ 13 хүүхэд үрчлэгдсэний 53.8 хувь нь 3 хүртэл насны, 15.3 хувь нь 10 ба түүнээс дээш насны, 3-6 насны, 7-9 насны хүүхэд байна. Эндээс харахад 3 хүртэлх насны хүүхдийн үрчлэлт их байна.

## ДҮГНЭЛТ

- Хүн ам, өрхийн мэдээллийн нэгдсэн цахим санд Говьсүмбэр аймгийн харьяат 17.5 мянган хүн бүртгэлтэй байгаагаас 290 нь буюу 1.7 хувь нь гадаадад зургаа ба түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж байна. Суурин хүн амын тоо өмнөх оноос 3.2 хувиар нэмэгджээ. Үүнд хүн амын цэвэр шилжилт болон цэвэр өсөлт сүүлийн 2 жилд нэмэх үзүүлэлттэй байгаа нь шууд нөлөөлж буйг илтгэнэ.
- Нийт багийн 50 хувь ( 5 баг) нь 1000-аас дээш, 50 хувь (5 баг) нь 1000-аас доош хүн амтай байна. Нийт хүн амд 0-15 насны хүүхдийн эзлэх хувь 2017 оноос 0.2 пунктээр, тэтгэврийн насны хүн амын эзлэх хувийн жин 0.4 пунктээр нэмэгдэж, хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувийн жин 1.4 пунктээр буурсан байна.
- Хүн амын дундаж наслалт 73.6 болж, өмнөх оноос 1.6 нэгжээр нэмэгдэж, улсын дунджаас 3.4 нэгжээр их байна.
- Хөдөлмөрийн насны 100 хүн өөрөөсөө гадна 56 хүүхэд, 10 тэтгэврийн насны хүн тэжээж байна. Өмнөх онтой харьцуулахад хүн ам зүйн ачаалал нь хүүхэд 2.7, тэтгэврийн насны хүн 0.9 пунктээр өссөн байна.
- Аймгийн нийт өрхийн тоо өмнөх оноос 0.4 хувиар нэмэгдсэн ба 4 баг нь 500-аас дээш өрхтэй, 6 баг нь 200-аас доош өрхтэй байна. Нийт өрхөд аймгийн төвд амьдарч буй өрхийн эзлэх хувийн жин 0.1 пунктээр нэмэгдэж, сумын төвд амьдарч буй өрхийн эзлэх хувийн жин өмнөх оны түвшинд байж, харин хөдөө амьдардаг өрхийн хувьд 0.2 нэмэгдсэн байна. Нэг өрхөд ногдох хүний тоо аймгийн төвд 1.7, сумын төвд 5.7 байхад хөдөөд 4.2 байна.
- Тайлант онд 498 хүүхэд төрсөн нь өмнөх оноос 19 хувиар нэмэгдсэн ба төрсөн нийт хүүхдийн 52.0 хувийг эрэгтэй хүүхэд эзэлж байна. Энэ нь шинээр төрсөн нийт хүүхдийн дүнд эрэгтэй хүүхдийн эзлэх хувийн жин өмнөх оноос нэмэгдсэнтэй холбоотой юм. Өмнөх оноос төрөлтийн ерөнхий коэффициент 2.5, төрөлтийн тусгай коэффициент 24.1, төрөлтийн нийлбэр коэффициент 0.9 промилээр нэмэгджээ. Эдгээр өсөлтөд төрөлт нэмэгдсэн нь шууд нөлөөлж байна.
- Нийт нас барсан хүний 64.4 хувийг эрэгтэйчүүд эзэлж байгаа нь өмнөх оноос 8.4 пунктээр буурчээ. Тайлант онд 1000 хүн тутмын 5 нь нас барсан нь 2017 оноос 0.7 промилээр буурчээ.
- Аймгийн хэмжээнд гэрлэлтийн ерөнхий коэффициент нь 5.1 байгаа ба 2017 оноос 1 промилээр, цуцлалтын ерөнхий коэффициент 1.0 болж, 2017 оноос 0.9 промилээр тус тус нэмэгджээ.

## Нэр томъёоны тайлбар:

- **Суурин хүн ам.** Тухайн баг, хорооны нутаг дэвсгэрт 6 сараас дээш хугацаагаар оршин суугаа бүх хүнийг суурин хүн ам гэнэ. Мөн 6 сараас доош хугацаагаар түр эзгүй байгаа байнга оршин суудаг хүмүүсийг суурин хүн амын бүртгэлд оруулна.
- **Өрх.** Ураг төрлийн болон гэр бүлийн холбоотой нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэж үзнэ.
- **Нэг өрхөд ногдох хүний тоо.** Нэг өрхөд ногдох хүний тоог тодорхойлохдоо өрхөд тоологдсон хүний тоог өрхийн тоонд харьцуулна.
- **Хүйсийн харьцаа.** Хүйсийн харьцаа гэсэн үзүүлэлт нь 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоог илэрхийлдэг.
- **Хүн ам зүйн ачаалал.** Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээлгэгчийн тоог харуулдаг.
- **Насны голч.** Хүн амыг насны бүтцийнх нь хувьд яг голлон хувааж байгаа насыг насны голч гэнэ.
- **Хүн амын нас-хүйсийн суварга.** Судалгаанд хүн амын нас, хүйсийн суваргаар нас, хүйсийн бүтцийг зураглан харуулдаг. Энэ нь зэрэгцүүлэхэд хялбар, хүйсний ялгавраар төв абцисс тэнхлэгээс хамгийн залуугаас эхлэн насны өсөх дарааллаар, доороос дээш суварган хэлбэртэй байна. Нас, хүйсний бүлэг бүр 100 хувьтай тэнцүү байна.
- **Төрөлтийн ерөнхий коэффициент.** Энэ үзүүлэлт нь тухайн жилд 1000 хүн амд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлдэг бөгөөд амьд төрсөн хүүхдийн тоог тухайн жилийн дундаж хүн амд харьцуулдаг.
- **Төрөлтийн тусгай коэффициент.** Төрөх насны буюу 15-49 насны 1000 эмэгтэйчүүдэд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлдэг.
- **Төрөлтийн нийлбэр коэффициент.** Төрөх насны эмэгтэйн төрүүлсэн нийт хүүхдийн дундаж тоо бөгөөд 1 эмэгтэйн эсвэл 1000 эмэгтэйн нийт амьдралынхаа туршид төрүүлэх дундаж хүүхдийн тоог илэрхийлдэг.
- **Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент.** Тухайн насны бүлгийн эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоог мөн насны бүлгийн эмэгтэйчүүдэд харьцуулсан харьцаа

- **Нас баралтын ерөнхий коэффициент.** Нас барсан хүний тоог тухайн жилийн дундаж хүн амд харьцуулсан харьцаа бөгөөд энэ үзүүлэлт нь 1000 хүн амд ногдох нас баралтын тоог илэрхийлдэг.

- **Насны бүлэг дэх нас баралтын коэффициент.** Тухайн насны бүлэгт нас барсан хүний тоог мөн насны бүлгийн хүн амд харьцуулсан харьцаа

- **Батлуулсан гэр бүлтэй.** Гэрлэлтээ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай хүмүүсийг “Батлуулсан гэр бүлтэй” буюу гэр бүлтэй гэнэ.

- **Цуцласан.** Гэр бүлээ хуулийн дагуу цуцалснаас хойших хугацааг харгалзахгүйгээр дахин гэрлээгүй хүмүүсийг салсан гэж тодорхойлдог.

- **Гэрлэлтийн ерөнхий коэффициент.** Иргэний гэр бүлийн байгууллагад тухайн жилд бүртгүүлсэн гэр бүлийн тоог тухайн жилийн дундаж хүн амд харьцуулсан харьцааг илэрхийлсэн үзүүлэлт.

- **Гэр бүл цуцлалтын ерөнхий коэффициент.** Шүүхийн болон захиргааны шийдвэрээр гэр бүл цуцлагдаж, тухайн жилд иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн гэр бүлийн тоог тухайн жилийн дундаж хүн амд харьцуулсан харьцаагаар илэрхийлэгддэг.

- **Хамруулсан хугацаа**

Үзүүлэлтүүдийг 2017-2018 оноор авч, өсөлт, өөрчлөлтийг өмнөх онтой харьцуулан тодорхойлов.

- **Мэдээллийн эх үүсвэр**

- Хүн амын жилийн эцсийн 2017, 2018 оны тайлан (ХА-3)

- Хүн амын ердийн хөдөлгөөний 2017, 2018 оны жилийн тайлан (ХА-1)

- Аймгийн Статистикийн эмхэтгэл, 2018 он

- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан – 1212.mn сайт